

ӨГЛӨГЧИЙН ХЭРЭМ ДОТОРХИ НЭГЭН МОНГОЛ БУЛШ (Үрьдчилсан үр дүнгээс)

С.Өлзийбаяр

ШУА-ийн Түүхийн хүрээлэн

Түлхүүр үг: Өглөгчийн хэрэм, монгол булш, ваар, дөрөө

Хэntий аймгийн Батширээт сумын нутаг дахь Өглөгчийн хэрмийг (Биндэр овооноос баруун хойш 12 км) Чингис хаан болон алтан ургийн ихэс дээдсийн шарилийг онголсон "Ихсийн газар" мөн хэмээн нэлээдгүй ярьж бичих боллоо. Өглөгчийн хэрэм нь Монголын түүх-археологийн хосгүй дурсгалуудын нэг боловч харьцангуй бага судлагдсан явдал нь дээрх таамаглал, яриа гарах эх үүсвэр болсон нь тодорхой юм. Уг хэрмийг анх судлаж шинжлэх ухааны тодорхойлолт хийсэн С.В. Кондратьев (Кондратьев 1926) түүнийг 12-14-р зуунь үеийн нум сумчдийн тулалдааны зориулалтаар хийгдсэн гэсэн бол манай ууган археологич Х.Пэрлээ Хятан улсын бэхлэлтийн хэрэм гэсэн санаагаа өөрийн бүтээллүүддээ тусгажээ (Пэрлээ 1957, 1959).

1990-ээд оноос хойш Өглөгчийн хэрмэнд хийх судалгаа нилээд эрчимжсэн байна. Тухайлбал Монгол-Японы хамтарсан "Гурван гол" экспедицийн судалгааны хүрээнд 1991-1992 онуудад өнгөц судлаж, түүвэр олдворт үндэслэж Киданы үеийнх гэдгийг хүлээн зөвшөөрчээ (Гурван гол 1991, 1992).

1994 онд Монгол-Солонгосын "Дорнод Монгол" төслийн экспедици мөн зарим хэмжилт хийж, цаг хугацааны хувьд Кидан буюу Ляо улсын үед хамрагдана хэмээн дүгнэжээ (Мон-Сол. 1999).

Ингэж уг хэрмийг Киданы үед баригдсан хэмээн үзэж ирсэн байна. Гэтэл Монгол-Америкийн хамтарсан "Чингис хаан" экспедицийн 2000, 2001 оны судалгааны үр дүнд "Өглөгчийн хэрэм нь бие даасан оршуулгын цогцолбор мөн. Үүнийг хүчирхэг улсын их хаан олон цэргийн хүчээр барилсан том бүтээн байгуулалт тул дэлхийн хаадын оршуулгын газруудтай эн зэрэгцэх том байгууламж тул Ихсийн газар гэж экспедицийн хамт олон үзлээ". (Базаргүр, Энхбаяр 2002 т-21) гэсэн сонирхолтой хувилбарыг дэвшүүлжээ. Хэрмийн бүтэц, зохион байгуулалтын талаар зохиогч 2002 онд хэвлүүлсэн (Өлзийбаяр 2002 а) Чингис хаан экспедици 2002 онд Өглөгчийн хэрмэнд суурин судалгаа хийж анх удаа энд нэлээд өргөн хэмжээнд археологийн малтальтуудыг хийж эхлэв. Эдгээрийн дотор хоёр өөр газраас илэрсэн хоёр өөр соёлын булшийг бүрэн малтан шинжилсэн судалгаа онцгой сонирхол төрүүлж байна.

Нэг нь тэмрийн түрүү үед холбогдох булш бөгөөд (Наваан 2002) нөгөө нь харин дундад зууны монголчуудын үйлддэг булш байна (Өлзийбаяр 2002 б)

Зохиогчийн малтсан монгол булшны талаархи судалгааны зарим үр дүнг үрьдчилсан байдлаар толилуулж байна. Энэ нь уг хэрмийг ихэс дээдсийн оршуулгын газар мөн эсэхэд хариулт өгөхөд нэлээдгүй ач холбогдолтой болох юм. Дашрамд язгууртны байж болохоор шинж тэмдэгтэй оршуулгын байгууламжийг одоо хэр бид хэрэмнээс илрүүлж чадаагүй байгааг дурдахыг хүсч байна.

Тухайн булш, нь хөрсөн дээр хойноос урагш 310см сунаж тогтсон, дунджаар 140см өргөнтэй, 30-40см өндөр чулуун өрлөг бүхий дараастай байв. 4x4м талбайд 20см гүн цэвэрлэгээ хийж тэдгээрийг ил гаргав (зур №1).



Дараасын зузаан хойд хэсгээр 38-40см, төв хэсгээр 70 см хүртэл, урдаа 40см орчим байна. 1-р чулуун дараасыг хуулах үед нугастай нимгэн төмөр эдлэлийн хугархай баруун урд хэсгээс 25см гүнд илрэв. Эхний чулуун дараасыг хуулсны дараа 230см урт, дунджаар 150см өргөнтэй 2-р чулуун дараас үргэлжлэв. Малтлагын талбайн хэмжээ 4х4м, гүн гадаргаас хамааран 15-35см. Энэ гүний түвшинд

киданы гэгдэх саарал ваарны хагархайнаас гадна модны нүүрсны үлдэц зэрэг хүний үйл ажиллагааны илрэл болсон зүйлс чулуун дараасаас ч хол зайд илэрч байгаа нь булшны нүхийг том хэмжээгээр үйлдсэн болохыг илтгэж байна. 2-р чулуун дараасыг хуулж цэвэрлэгээ хийхэд доорос нь болон хажуу талаар нь соёлт давхарга үргэлжлэв.

Талбай 250x330 см болж хумигдан доош үргэлжлүүлэн малтахад В-1 хавтгайд 76 см гүнээс киданы гэгдэх саарал, улаавтар керамик, шатсан модны нүүрс маш элбэг олдож байна. Мөн В-2 хавтгайд 90см гүнд 12x15 харьцаатай 3 см зузаан ваарны хагархай гарав. Ийм төрлийн ваар хэрмийн бусад хэсгийн малтaluудаас ер илрээгүй юм. С-2 хавтгайд хүнийх байж болзошгүй маш муудсан нимгэн ясны хуудас олдов. 90 см – н гүнээс нүхний баруун, зүүн, өмнө захуудаас байгалийн хөрс гарч эхэлсэнд, бид малтлагын талбайгаа хүмин багасгав. Малтлагын явцат 110 см гүнээс А-2 хавтгайд 3 шагай, 112 см гүнээс А-3 хавтгайд



йртэй төмөр хугархай, 115-120 см гүнээс 3-р шугамын дагуу сунасан булшны нүхний толбо тодоор илрэв. 60 см өргөн, 240 см урт ба хойд талаараа том үхэр чулуунд, урдуураа байгалийн чулуун судалд тус тус тулсан байрлалтай. Чулуурхаг хөрстэй тул баруун талаас бусад нь байгалийн чулуунд хашигдсан байна. Булшны нүхний хэмжээгээр доош 20 орчим см малтахад 142 см гүнээс модон авсны хэсэг цухуйснаар хойд зүгт хандуулан тавьсан оршуулга илрэв. 147 см гүнээс хүний зулайн яс мэдэгдэж, толгойн талд авсны гадна хонины шаант чөмөг түшүүлэн тавьжээ. Хайрцгийг маш ховор тохиолдол болох бүдүүн мод хөндийлж ухаж бэлдсэн бөгөөд шарилын дээгүүр холтсоор хучсан байна. Хайрцагны дотор талыг шатааж ариутгасан бололтой юм. 150 см гүнд авсны гадна дээд талд сэнж нь сэтэрсэн дөрөө, баруун ташаа орчим мөн авсны гадна талд ханыг нь түшүүлэн

нөгөө дөрөөг доош нь харуулан тавьсан байна. 165 см гүнд авсны модны урд зах илэрснээр нийт хайрцагны эргэн тойрон тодорхой боллоо. Мод нь их хэмжээгээр ялзарч муудсан учраас амархан үйрч байна. Хайрцагны зузаан толгой талдаа хамгийн их ба тэнд 19,3 см бусад хэсгээр 5 см орчим маш нимгэн хальс төдий болжээ. Өргөн толгой талаасаа 1 м-т 46 см, 2м-т 44 см урт нь 215 см. Хүний яс анатомийн зохион байгуулалтаараа бөгөөд, баруун гарыг тохойгоор нугалж аарцагны орчим тавьсан, зүүн гарыг ташаан дагуу сул унжуулан толгойг ялимгүй хазгай боловч чанх хойд зүгт хандуулан тавьжээ. Шүдний элэгдэл, гавалын болон урт ясны шинжээр нь уг оршуулга нь 60 орчим насны эр хүнийх бололтой гэж тодорхойлж болмоор байна. Ясны хадаглалт маш муу бөгөөд дээгүүр нь дарсан холтсыг хаман авч бүх ясиг ил гаргаад, хайрцагны гадуур баруун талаар булшны нүхнийг 10 см өргөсгөж доош нь 20 см гүнзгийлж цэвэрлэв. Баруун дунд чөмөгний төгсгөл /өвдөг/ орчим, дөрөөнөөс урагш 18 см зайд хайрцагны доогуур шургуулж хийсэн байдалтай амгай, зуузай/ зуузайны өрөөсөн нь хайрцагны доор үлдсэн байж болзошгүй/ олдлоо. Эдгээрээс өөр эд өлгийн зүйл илэрсэнгүй. Уг булшийг Өглөгчийн хэрмэнд цаашид судалгаа үргэлжлүүлэн явуулахтай холбогдуулан битүүмжлэн үлдээлээ.

-Олдворуудын дүн шинжлэл

а-төмөр эдлэл

1- нугастай төмөр эдлэлийн хэлтэрий


1-р чuluун дараасын баруун урд талд, киданы саарал ваарны хагархайнуудын хамт 25 см -ийн гүнээс олдлоо. Хамгийн өргөн хэсгээр 9 см, өндөр нь дунджаар 5 см бөгөөд балбаж хийсэн зузаавтар төмөр эдлэл /бүдүүвчлэсэн зур/.

Дээд талд нь сэтэрхий гаргаж, нугас хийсэн нь ямар нэгэн зүйлийн таг болох нь тодорхой. Хадаасаар цоолж нүхэлсэн тогтоогчтой. Хурц иртээр хайчилсан болон цоолсон шинжээр, түүнчлэн бага зэвэрсэн, гүнээс биш харин хөрсөн дээр шахуу чuluун дараасын дундаас илэрсэн зэргээр нь булшны зан үйлтэй холбоогүй харин хожим тохиолдлоор энд гээгдсэн болохыг гэрчлэж байна. Хэдий тийм боловч энэ нь хэрмийн ашиглалт, зориулалтыг тогтооход чухал ач холбогдолтой юм.

2- төмөр багажны ир /хугархай/

Оршуулгын толгойн хэсгийн 115 см гүнээс олдов. Энэ нь булшинд дагалдуулан тавьсан эд өлгийн зүйл биш

борох нь булшны нүхний толбоос 30 орчим см-н дээр байгаагаар тайлбарлагдана. 2.7-3.0 см өндөр, ирний хэсгийн өргөн 6 см, дээд хэсгийн өргөн 4.9 см, дээд хэсгийн зузаан 1.2 см бол доод тал руугаа 2 талаасаа жигд нимгэрэн хурц ир үүсгэсэн. Дээд хэсгээр тууш ховил байгаа нь дундаа иш суулгах зориулалттай нүхтэй байсныг гэрчлэх бөгөөд дээд болон хоёр талаараа хугарсан ул мөр тод үзэгдэнэ. Энэ нь хурц иртэй зэвсэг бөгөөд магадгүй тухайн оршуулгыг үйлдэхэд ашиглаж байсан сүх хэлбэрийн цавчдаг хэрэглэл байжээ. Ажлын үед хэлтрэн



унаж хадаглагдаж хоцорсон бололтой бөгөөд энэ түвшинд булшны нүхний хэмжээ эрс багассанаар тайлбарлагдаж болох юм. Өөрөөр хэлбэл энэ багаж нь хөдөлмөрийн голлох зэвсэг байсан ба хугарснаар цааш тийм том талбайгаар ухах боломжгүй болж зөвхөн авсны хайрцагны хэмжээгээр доош үргэлжлүүлэхэд хүргэжээ. 250 x 330 см харьцаатай 100-105 см гүн нүх ухсан нь мал, амьтны яс, керамик хагархайнууд, модны нүүрс болон маш ихээр холилдсон шороон давхаргаас мэдрэгдэж байлаа. Иймээс бид тухайн байгууламжийг нэлээд том зохион байгуулалттай булш байх гэж таамаглаж байв.

3 -Хос дөрөө


Эдгээр дерөөнүүдийг хайрцагны гадна талд тавьсан ба үүний нэг өрөөсөн нь нас барагчийн зүүн гар талын ташаан толгойн орчим 150 см гүнд сэнжийг нь дотогш харуулан авсны хайрцаг дээр хөндлөн тавьсан байрлалтай байна. Нөгөө дерөө нь баруун гар талд нь, шарилийн дунд чөмөгний төгсгөлийн харалдаа 151 см гүнд авсны ханыг түшүүлэн, сэнжийг доош нь харуулан тавьсан байлаа. Хоёр дерөөнү таваг нь сэтэрсэн, тэдгээрийн хугархай нь хамт олдов. Зүүн талаас олдсон дерөөний сэнж нь сэтэрчээ. Монгол булшинд элбэг тохиолддог дерөө дагалдуулах ёс энд давтагдаж байна. Дөрөө нь хэмжээгээрээ оршуулгийн эзний нас биеийн байдалд тохиорхгүй харин хүүхдийнх байгаа нь нэлээд сонирхол төрүүлж байна. Энэ нь нас эцэслэсэн ойр дотны хүндээ дахин төрөх хүслийг бэлгэдэн хүүхдийн дерөө дагалдуулсан байж болох талтай. Нөгөөтэйгүүр булшинд дагалдуулсан эд өлөг нь ямар нэгэн хэмжээгээр талийгчийн эдлэж, хэрэглэж байсан зүйл хэмээн тайлбарлах догматик ойлголтыг эргэн хараад хүргэж болох юм.

4 -Амгай,зуузай.

Нас барагчийн баруун гар талд, дерөөний байрлалаас урагш 18 см – н зайд авсны доогуур шургуулан тавьсан 2 цагариган амгай, 1 зуузайны хамтаар илрэв. Эдгээр амгай, зуузай нь манай малчдын өргөн хэргэлэж байгаа цагариган амгай, S хэлбэрийн зуузайтай ялгагдхааргүй адилхан байгаа нь нүүдэлчдийн мал ахуйтай харьцах соёл олон мянганыг ардаа орхиж тогтсон хэлбэрийг олон, хөгжлийн хөгжингүй шатандаа эрт үед орсоныг гэрчлэж болох юм. Авсны дор өрөөсөн зуузай нь үлдсэн байж болох юм. Учир нь амгай зуузайг салгаж тусгайд нь дагалдуулсан биш харин хазаарыг дерөөний хамт тавьсан байж болох юм. Энэ нь монгол хүн морьтойгоо гэсэн санааны илэрхийлэл бэлгэдэл бололтой.

б-керамик Булшны нүхнээс хамгийн их тоотой илэрсэн нь ваарны хагархайнууд юм. Гэхдээ эдгээр нь бүгд булшны зан үйлтэй шууд холбогдохгүй нь

мэдээжийн хэрэг юм. Ихэнхи нь хэрмийн бусад хэсгээс элбэг олддог ваарны хагархайнуудын адил бөгөөд нааж эвлүүлэх боломжгүй байгаа нь тохиолдлоор энд булагдсаныг харуулж байна. Эдгээр керамикуудыг хийцээр нь 4 хувааж болохоор байна. Бүгд 30-100 см хүртэл



Гүнээс илэрсэн.

Зураг №4 - 1,3 - киданы гэгдэх ваарнууд .

Малтлагын явцат харилцан адилгүй гүний түвшинд ганц нэгээр илэрч байсан керамикийн төрөл юм. Үүнд:

а - нимгэн цэвэр хийцтэй улаан шаргал ваар.

Эдгээр нь бөөрний хэсгээр түлэгдсэн хар өнгөтэй амсарын хэсгээр босоо цохилтот хээтэй, доод хэсгээр цулгай. Ерөхийдөө хэрмийн бусад хэсгээс олдог киданы саарал ваарнуудтай адил юм. Булш үйлдэх зан үйлийн үед булагдсан бололтой /зураг №4/.

б - зузаавтар, харьцангуй болхи хийцтэй ваар.

Ийм төрлийн ваар хэрмийн бусад хэсгээр маш элбэг тархсан төдийгүй, булшны нүхэн дотроос ч олноороо илэрч байна. Эдгээрийн дотор 103 см гүнд буюу мөн төрлийн хийцийн ваарны илэрсэн нь хамгийн гүн түвшинд хүний толгой орчмоос олдсон нь сонирхол төрүүлж байна. Тэр нь бидний дээр үзүүлсэн нимгэн улаан шаргал ваарны амсартай өнгө хийцийн хувьд яг адил боловч зузаан, нум багатай ваарны амсар юм. Энэ шинжээр нь их багтаамжтай, том савных болохыг мэдэж болно. Иймээс уг вааран эдлэлийн хагархайг санамсаргүй байдлаар уг нүхэнд булагдсан бус харин булшны эзнийг оршуулах зан үйлтэй ямар нэгэн хэмжээгээр холбогдуулж болохоор байна.

Зураг №4 – 2 маш хатуу хөх тоосгон керамик.

Ийм төрлийн керамик хэрмийн бусад хэсгийн малтлагаас огт илрээгүй бөгөөд зөвхөн тухайн булшны малтлагын талбайн В-1 хавтгайд 76 см гүнээс илэрсэн ба хэлбэр зориулалт нь тодорхойгүй бөгөөд булшинд дагалдуулан тавьсан зүйл байж болох юм.

Зураг № 4 - 4 нимгэн саарал керамик

Булшны толгой талд малтлагын В-2 хавтгайд 95 см гүнээс илэрсэн. Маш цэвэр хийцтэй, гадна талдаа хээгүй, дотроо нарийн тууш судалтай, саарал өнгөтэй. Том савны ёроолын хэсэг байж болмоор / Зураг №4/.

Эдгээрээс гадна янз бүрийн жижиг ваарны хагархайнууд илэрсэн нь том талбайгаар нүх ухаж оршуулга үйлдсэнтэй холбоотой. Булшны нүхэнд талийгчид зориулсан зан үйлээр хийгдснээс гадна хэрмийн бусад хэсэгт элбэг тархсан хаягдмал ваарнууд энд оршуулгын үед булагджээ.

в бусад зүйлс

-яс. Эдгээрээс их онцлогтой нь булшны толгойн талд авсны гадна босоо байрлалтай түшүүлэн тавьсан хонины шаант чөмөг юм. Хонины шаант, дал, дөрвөн өндөр хавирга монголчуудын оршуулгаас илрэх нь олонтоо тохиолддог. Шаант чөмөг тавьсан нь талийгчдаа хүндэтгэл үзүүлэх монголын оршуулгын уламжлалт зан үйл билээ.

-3 шагай. 110 см гүнд, малтлагын А, В хавтгайн зааг дээр, шарилгийн толгойн дээд хэсэг, болон авсны дээд ирмэгээс 40 см орчим дээр, булшны нүхний хар толбоос баруун тийш даруй 52 см зайд тавьжээ. 3 шагай мөн монголчуудын оршуулгын зан үйлд өргөн хэрэглэгддэг зүйл билээ.

Мал амьтны чухам юу нь үл мэдэгдэх ясны өөдөс, хугархайнууд булшны нүхнээс цөөнгүй илэрлээ. Тухайлбал үхрийн байж болохоор нүдний ухархайны доод талын томхон хэсэг байна.

-цахиур. Булшны малтлагын явцад цахиуран цуулдас, үлдэц зэрэг микролитууд олон тоогоор гарч байлаа. Энэ нь чулуун зэвсгийн үед /неолит/ хүмүүс үүгээр нутагшиж байсныг гэрчлэж болох боловч /Рашаан хадны дурсгалаас 10км/ зарим цөөн тохиолдолд монголчууд оршуулгын зан үйлд галыг болон ямар нэгэн зүйлийг бэлгэдэн цахиур дагалдуулдаг байсантай холбогдож болох юм.

Оршуулгын онцлог, цаг хугацааны хамаарал

Оршуулгыг дунджаар 150 см гүнд, тэргүүнийг нь хойш нь хандуулан, биеийг нь тэнэгэр байдалтай тавьсан болон хазаар, дөрөө, хүндэтгэлийн идээ шаант чөмөг, цахиур зэрэг монголчуудын оршуулгын зан үйлийн соёлын нийтлэг дүр төрхийг илэрхийлсэн эд өлгийн зүйлсийг дагалдуулжээ. Түүнчлэн газар сонгосон байдал, чулуун өрлөг, дараасын хэлбэр зэрэг оршуулгын зан үйл,

материаллаг соёлын зүйлсээр монгол булш болохыг хөдөлбөргүй тодорхойлж байна.

Дундад зууны Монголчуудын оршуулгын зан үйлд хүнээ автай болон огтхон ч авсгүй оршуулах 2 хэлбэр буй. Автай оршуулга нь ихэнхи тохиолдолд бансыг углуурга гаргаж хайрцаг хийж тагласан байдаг ба чулуугаар хашлага хийж үйлдсэн ч байдаг. Харин энэ тохиолдол шиг бүдүүн мод хөндийлэн ухаж авс хийсэн нь маш ховор юм. Ингэснээр монголчууд оршуулга үйлдэхдээ олон хэлбэрээр авс хийдгийн дотор мод ухаж хийх хэлбэр байсныг ийнхүү нотлон байна. Гэхдээ оршуулгын бусад мэдээ сэлт зан үйлүүдтэй нарийвчлан холбож үзэх шаардлагатай байгаа юм.

Тухайн булш Өглөгчийн хэрэм дотор харьцангуй өндөр газар байрлаж байгаа нь хэрмийн зориулалтыг нарийвчлан судлах, улмаар Ихсийн газар байж болох эсэхэд хариулт өгөхөд чухал ач холбогдолтой юм.

Булшиг хөндөлгүй цаашид хэвээр үлдээж, хадгалах болсонтой уялдаад нүхийг анх малтснаас ихээхэн өөрчлөв. Ингэснээр анх хийсэн гар зурагнаас их өөрөөр харагдаж нь тодорхой.

Ном зүй

Базаргүр.Д,Энхбаяр.Д. "Чингис хааны төрсөн ба оршуулсан газар". УБ., 2002
Кондратьев СВ,Краткая заметка о старинной крепости в Углекчи. 1926, ШУАТХ

ГБФ ф/х т-6

Мон-Сол төслийн 1997-1998 оны тайлан СҮМ,МҮТМ,ШУАТХ УБ., 1999

Монгол-Японы хамтарсан „Гурван гол,, экспедицийн тайлан 1991,1992 ШУАТХ
ГБС

Наваан Д. Чингис хаан экспедици ЭША,-ын тайлан 2002 /нэгдсэн тайлан/
Өлзийбаяр С. Өглөгчийн хэрмийн хөдөлмөр цагийн тооцоо// Нийгэм

хүмүүнлэгийн боловсрол сэтгүүл №2, 2002

Өлзийбаяр С. Чингис хаан экспедици ЭША-ын тайлан 2002 /нэгдсэн тайлан/

Пэрлээ Х. Монгол орны археологийн шинжилгээний товч тойм 1957

Монголын нүүдэлчдийн металлурги боловсруулалтын асуудал 1959 //Х.Пэрлээ

Эрдэм шинжилгээний өгүүллүүд УБ, 2001

Пэрлээ Х. Эрт дундад үеийн хот суурингийн товчоон УБ, 1961

Summary

S.Ulziibayar

A Mongolian period grave within Uglugch wall

The Mongolian period grave, excavated within Uglugch wall, Batshireet sum, Khentii aimag, Mongolia, reflects common features of an ordinary person's burial ritual of that historical period. The incidence that a coffin in the grave was made out of wood by hollowing it out attracts an interest of archaeologists, as in historical sources it mentions that a coffin of a high rank person was made by hollowing out a wood.